



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/516

Чойбалсан

Г Тусгай зөвшөөрөлд байршлын өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтууд, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 400 дугаар тушаал, "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс"-ын 2022 оны хоёрдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Дорнын очирт мандал" ХХК-ийн "Оюу" эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд байршлын өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг "Дорнын очирт мандал" ХХК-ийн захиралд үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хууль төгтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба (Ч.Оюунаа), Мэргэжлийн хяналтын газар (Д.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

0101 1423

Аймгийн Засаг даргын 2022 оны  
09 дугаар сарын 20 ны өдрийн  
456 дугаар захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ БУЙ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үйл ажиллгааны чиглэл	Хуучин байршлын хаяг	Шинэ байршлын хаяг
1	"Дорнын очирт мандал" ХХК	"Оюу" эмийн сан	ЭСХ- 16/09/882	Эмийн сан /II зэрэглэл/	7-р баг 30-р байр 1 тоот	6-р баг Шүр захын хойно Худалдаачны 2 дугаар гудамж 150-2 тоот